



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар A/152

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын дулааралттай холбоотойгоор цас ихтэй нутгууд, уулархаг газар, гуу, жалга, гол, мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасах үед иргэд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчин осолдох, хуурай сайраар шар усны үер бууж хүний амь нас хохирох, эд хөрөнгийг сүйтгэх аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Хаш-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

Гишүүд:
Г.Балжиням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахмад)

О.Мөнхсайхан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга)

П.Нямсүрэн (АЗЗА ТӨХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер)

С.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г.Алтанцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын ангиллын сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Хаш-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0280

D:My Doc. Zahiramj. Zasag darga